



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

Ор хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/479 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Голд элиза” ХХК –ний эмнэлэгт нэмэлтээр уламжлалт эмчилгээний 10 ор, “Апекс менежмент” ХХК-ний эмнэлэгт өвчний хурц үеийн 10 ор, өвчний хурцавтар үеийн 10 ор, сэргээн засах эмчилгээний 10 ор, “Ивээлт аметист” ХХК-ний эмнэлэгт өвчний хурц үеийн эмчилгээний 10 ор, өвчний хурцавтар үеийн 5 ор, “Бриллианс клиник” ХХК-ний эмнэлэгт нэмэлтээр өвчний хурц үеийн эмчилгээний 10 ор, өвчний хурцавтар үеийн эмчилгээний 10 ор, сэтгэцийн 5 ор, хөнгөвчлөх асаргаа сувилгааны 15 орыг тус тус хуваарилсугай.
2. “Төгсүн” ХХК-ний өвчний хурц үеийн 9 ор, хурцавтар үеийн 3 ор, архаг үеийн 3, нийт 15 орыг сэтгэцийн оронд шилжүүлсүгэй.
3. Эрүүл мэндийн байгууллагын батлагдсан орны хязгаарт багтаан үзүүлж буй тусламж, үйлчилгээнд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс /М.Мөнхдэлгэр/-т даалгасугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Л.Зэндмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

1150500018